

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХЫГ ТҮР ХОРИГЛОХ, ТЭДГЭЭРИЙН ҮР АШИГ, МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /цаашид “тогтоолын төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

- ✓ Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- ✓ Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- ✓ Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- ✓ Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6-н шалгуур үзүүлэлтээс дараах 3-н шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

1. Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн тогтоолын төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд тогтоолын төслийн зохицуулалт нь тогтоолын төслийн үзэл баримтлал буюу тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2. Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар тогтоолын төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

3. Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлага хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

ГУРАВ. ТОГТООЛЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгуур үзүүлэлтийг сонгох
1.	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төслийн холбогдох зохицуулалт	“Зорилгод хүрэх байдал” нь тухайн тогтоолын төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Тогтоолын төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Тогтоолын төслийг бүхэлд нь хамруулах	“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн заалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
3.	Харилцан уялдаа	Тогтоолын төсөлд зохицуулалтыг	Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах

		бүхэлд нь хамруулах	
--	--	------------------------	--

ДӨРӨВ. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тогтоолын төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон тогтоолын төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл:

Монгол Улсын **Үндсэн хуулийн Тавдугаар зүйлд** Монгол Улс дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байх, төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах буюу гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах, төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар тусгасан байдаг бөгөөд УИХ ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан **“Алсын хараа-2050”** Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн **Зорилго 4-т** “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж тусгасан нь **эрхэм зорилготой нийцэж буй** явдал юм.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах зорилгоор санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулах, мөн эдгээр хуулийн этгээдийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжиж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулснаар **“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” УИХ тогтоолын “2.1.3.төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх”, “2.1.7.авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих” мөн Алсын хараа 2050-ийн Нэгдүгээр үе шат буюу 2021-2030 оны хооронд хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж,**

төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна” гэж тусгасан нь **эрхэм зорилготой тус тус нийцсэн байна.**

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох хяналтыг сайжирч, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн боломжит хэсгийнх нь хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр гарган арилжин, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх Шинэ сэргэлтийн бодлогын 6.4-т заасан заалтын хэрэгжилтийг эрчимжих болно. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох хяналтыг сайжруулж олон улсын жишигт хүргэж баймаажин төрийн өмчийн аливаа хулгайгаас сэргийлж, авилгын индекс буурна.

Мөн гадаадад хувьцаа нь арилжаалагдаж буй Монголд бүртгэлтэй компаниудын хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалах эрх зүйн үндсийг тавьсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 6.4 дахь зүйлийн хэрэгжилтийг гүйцэд хангагдахад энэхүү тогтоолын төсөл чухал нөлөөтэй байна.

2. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Тогтоолын төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.

29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.

30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

3. Уялдаа холбоог шалгасан эсэх

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь стандарт асуултад хариулах замаар тогтоолын төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
2	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
5	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
6	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
7	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
8	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тогтоолын төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
9	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Тогтоолын төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.

10	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
11	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тогтоолын төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
12	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
13	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тогтоолын төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

5.1 Дүгнэлт

Дотоодын нийт бүтээгдэхүүнд төр шууд бусаар буюу төрийн өмчит аж ахуйн нэгжээр дамжуулан нийлүүлэлт хийж байгаа хэмжээ нь сүүлийн 9 жилийн дунджаар 22.3 хувь, шууд байдлаар буюу төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 33.3 хувь байна. Өөрөөр хэлбэл давхардсан тоогоор Төр дотоодын нийт бүтээгдэхүүний 55.6 хувийг дангаараа бүрдүүлж байна. Хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн бүтэцтэй улсуудтай харьцуулж үзэхэд урвуу үзүүлэлт бүхий үр дүн гарч байна. Ийм хэмжээний өндөр нөлөөллийг бууруулж, төр компани байгуулах замаар бизнес хийдэг, хувийн хэвшилтэй өрсөлддөг байдлыг зогсоох, цаашид эдийн засаг дахь төрийн оролцоог хумих бодлогыг эрчимжүүлэх нь уг тогтоолын төслийн зорилго юм.

Мөн тогтоолын төсөл батлагдан хэрэгжиж эхэлсэнээр гарах үр дүн нь сүүлийн 7-н жилийн математик дунджаар жил бүр 39-н байгууллагыг төр шинээр байгуулж байгаа байдлыг тодорхой хугацаанд зогсоох явдал. Шинээр байгуулах асуудлыг зогсоож, одоо байгаа 5901 төрийн болон төрийн оролцоотой байгууллагыг хэрхэн зөв зохион байгуулалтад оруулах, багасгах ажлыг богино хугацаанд хийх нөхцөл бүрдэнэ.

Тогтоолын төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Тогтоолын төслийн зохицуулалт нь уг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн тогтоолын төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн.

Тогтоолын төслийн дугаар зүйл бүрийн хувьд уг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж зорилгод хүрэх байдлаар томъёологдсон байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Харилцан уялдаатай байдлыг хангасан.

Иймд тогтоолын төслийг батлан, хэрэгжүүлэх нь Монгол Улсын эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, хувийн хэвшилд орон зай, боломж нээж өгөх, эрүүл эдийн засгийн суурийг бэлтгэхэд чухал нөлөөлөл үзүүлнэ.